

**ҮЙЛДВЭРЖИЛТ 21-100 ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**
(2020 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл			
1.	“Үйлдвэржилт 21-100” үндэсний хөтөлбөр (2018-2021) ЗГ-ын 36 дугаар тогтоол	Хөтөлбөрийн зорилго: Орон нутгийн онцлог, нөөцөд суурилан дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, нэмүү өртөг шингэсэн, олон улсын чанар, стандартын шаардлага хангасан, өрсөлдөх чадвартай зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлж, ажлын байр, гадаад, дотоод худалдааны эргэлт, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.			
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	<ul style="list-style-type: none"> • Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт; • Улсын болон орон нутгийн төсвийн дэмжлэг; • Гадаадын зээл, тусламжийн хөрөнгө; • Концессын гэрээ; • Бусад эх үүсвэр. 			
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	<p>Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам</p> <p>Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Сангийн яам, ГХЯ, ХНХЯ, БСШУСЯ, УУХҮЯ, БОАЖЯ, БХБЯ, ЭХЯ, БХЯ, ХЗДХЯ, ГЕГ, ТЕГ, МХЕГ, СХЗГ, МҮХАҮТ, Аймаг нийслэлийн ЗДТГ, ҮХГ, ХХМТГ, НҮИГ, ОУБ, ШУТСан, Монгол банк, Хөгжлийн банк, ЕСББ, АХБ, СЗХороо, ДБМ лизинг, ЖДҮХС, ХААБ, ТЭДСан, МХС, МЭЕГ, Мэргэжлийн холбоод, ТББ, ШУА, ШУТИС болон бусад их дээд сургуулиуд, МСҮТ, ААН-үүд</p>			
4.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p>Зорилт 1. Үйлдвэрлэлийг санхүү, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих, эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх, түүхий эд, бүтээгдэхүүний чанар, стандартыг нэвтрүүлэн нутагшуулж, олон улсын болон бүс нутгийн түвшинд хүргэх;</p> <p>Зорилт 2. Түүхий эд бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгож, түүхий эдийн нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлэх</p> <p>Зорилт 3. Түүхий эд бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгож, түүхий эдийн нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлэх</p> <p>Зорилт 4. боловсруулах үйлдвэрийн хөгжлийн чиг хандлага, эрэлтэд нийцүүлэн хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах, ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;</p> <p>Зорилт 5. Зорилтот зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүний тээвэр-ложистикийг боловсронгуй болгож, маркетингийн үйл ажиллагааг хөгжүүлэн дотоод, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх.</p>			
5.	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал, сая.төг)	Нийт-3,045,105.5		
		Үүнд: 2020 онд	Төсөв (он)	Гүйцэтгэл	Хувь
		Улсын болон орон нутгийн төсөв	30,610.0	14,868.5	48.6
		Гадаадын зээл, тусламж, хувийн хөрөнгө оруулалт	795,374.0	23,968.0	3.0
		МУХБ, УБХБ	200,000.0	104,900.0	
		1,025,984.0	143,736.5	14.0	
6	Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хавсралтаас үзнэ үү.				
7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	<p>1. “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөрийн 2020 оны жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний ерөнхий дундаж 78.8 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэсэн үнэлгээгээр дүгнэгдэв.</p> <p>2. Шалгуур үзүүлэлтийн биелэлтийг авч үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хэмжээ 12 хувь буюу өмнөх оны түвшинд, ➢ Арьс ширэн түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин өмнөх оноос 2.5 хувиар өссөн, 			

		<p>➢ Ноос, ноолууран түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин өмнөх оноос 2.5 хувиар,</p> <p>➢ Хүн амын хэрэгцээнд үйлдвэрийн аргаар боловсруулж нийлүүлсэн махны хэмжээ өмнөх оноос 21 хувиар буурсан,</p> <p>➢ Сүүний үйлдвэрлэлийн эзлэх хэмжээ 30.6 хувиар өссөн дүнтэй байна.</p> <p>➢ Шинээр байгуулагдсан үйлдвэр: ЗГ-ын 36 дугаар тогтоолын хавсралтад батлагдсан үйлдвэрээс тайлант онд нийт 8 аймагт шинээр бүрэн ашиглалтад орсон 4, бүтээн байгуулалтын ажил болон өргөтгөл хийгдэж буй 5, нийт 2018-2020 онд 81 үйлдвэр бий болсон. 2020 онд ЖДҮХС-750.5 сая, гадны хөрөнгө оруулалт 441.8 сая, өөрийн хөрөнгө оруулалтаар 2,775.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн,</p> <p>➢ Ажлын байр өмнөх оноос 400-аар нэмэгдсэн байна.</p> <p>Тайлант 2020 онд дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахал, бүтээгдэхүүний гадаад зах зээлийн үнийн бууралт, худалдан авах чадварын бууралт, экспортын тээвэрлэлт, үйлдвэрлэлийн сул зогсолт зэргээс шалтгаалж төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна. Улс орны эдийн засаг 2021 онд сэргэж, бодлогын чанартай арга хэмжээг хурдан хугацаанд авч хэрэгжүүлбэл “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр зорилтот түвшиндээ хүрэх боломжтой хэмээн дүгнэж байна.</p> <p><u>Ололттой тал:</u></p> <p>Монголын Ноос Ноолуурын Холбооны дэргэд “Баталгаажуулалтын албыг байгуулсан. Тус алба нь олон улсын MNS ISO/IEC17065 стандартын шаардлагыг бүрэн хангасан тул үндэсний болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн төдийгүй МУ-ын ноос ноолуурын салбарын “Тохирлын үнэлгээ-Бүтээгдэхүүн, үйл явц, үйлчилгээний баталгаажуулалт”-ыг явуулах эрх бүхий байгууллага бий болсон.</p> <p>- Монгол Улс ноолууран бүтээгдэхүүнээ “Монголын Хаан ширхэгт” чанарын тэмдэгээр баталгаажуулан экспортод гаргаж эхэлсэн.</p> <p>-ХХААХҮС-ын 2020 оны 11 дүгээр тушаалаар 1643 малчин, 16 ЭМАА эрхлэгчдэд үйлдвэрт тушаасан сүүний урамшуулалд 766.7 сая төгрөг олгов.</p> <p><u>Дутагдалтай тал, тулгамдсан асуудал:</u></p> <p>-Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль хүчингүй болсон. Иймд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих чиглэлээр яаралтай холбогдох хууль эрх зүйн баримт бичгийг боловсруулж, эрх зүйн орчныг сайжруулах,</p> <p>-Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх шаардлагатай.</p>						
8	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, аймаг, нийслэлийн ЗДТГ, ОУ-ын төсөл хөтөлбөрүүд, үйлдвэр аж ахуй нэгж, иргэд хөтөлбөрийн зорилго, зорилтын хүрээнд хийгдэж байгаа хамтын ажиллагаа, уялдаа холбоог “Хангалттай” гэж үнэлж байна.						
9	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ(өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж 78.8%	Зорилтын тоо 5	Зорилт 1 85.0	Зорилт 2 85.7	Зорилт 3 89.2	Зорилт 4 57.0	Зорилт 5 77.0
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын)	Нэгдсэн үнэлгээ, %						

Хөтөлбөрийн 2020 оны шалгуур үзүүлэлтийн биелэлт

№	Шалгуур үзүүлэлт	нэгж	Суурь түвшин, 2016 он	Зорилтот түвшин, 2021 он	2019 онд	2020* онд	Биелэлт, %	
							Суурь түвшинтэй харьцуулахад	Зорилтот түвшинтэй харьцуулахад
1.	Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жин	хувь	9	15	12	12	133.3	80.0
2.	Арьс, ширэн түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин	хувь	36	60	40	41	113.9	68.3
3.	Ноос, ноолууран түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин	хувь	20	60	25.2	26	130.0	43.3
4.	Хүн амын хэрэгцээнд үйлдвэрийн аргаар боловсруулж нийлүүлсэн махны үйлдвэрлэлийн эзлэх хэмжээ	хувь	6	30	6.2*	4.9	81.7	16.3
5.	Хүн амын хэрэгцээнд үйлдвэрийн аргаар боловсруулж нийлүүлсэн сүүний үйлдвэрлэлийн эзлэх хэмжээ	хувь	9	40	17.0	22.2	246.7	55.5
6.	Шинээр байгуулагдсан үйлдвэрийн тоо	тоо	-	100	61.0	81	-	81.0
7.	Шинээр бий болгох ажлын байр (хүний тоо)	тоо	-	6000	3700	4100	-	68.3
8.	Олон улсын түвшинд хүрсэн стандартын нийт стандартын дүнд эзлэх хэмжээ	хувь	42	50	37.2	38	90.4	76.0

ҮЙЛДВЭРЖИЛТ 21:100 ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ

2020 оны жилийн эцэс

Д/д	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2020 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Нэгдсэн дүгнэлт	Үнэлгээ
14.1. Үйлдвэрлэлийг санхүү, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих, эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх, түүхий эд, бүтээгдэхүүний чанар, стандартыг нэвтрүүлэн нутагшуулж, олон улсын болон бүс нутгийн түвшинд хүргэх;						
1	14.1.3. Түүхий эдийн сангийн эх үүсвэр бий болгох шийдвэрийн төсөл боловсруулж батлуулах, санг бүрдүүлэх	2019 - 2021	108,900.0 сая төг		Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн тухай хуулийн 4.10 дахь заалтыг үндэслэн хөдөө аж ахуйн биржээр дамжуулан түүхий эдийг бэлтгэх зорилгоор Түүхий эдийн сангийн эх үүсвэр бий болгох саналыг боловсруулж, удирдлагад танилцуулсан. 2020 онд Хөгжлийн банкны эх үүсвэрээр ноолуур бэлтгэлд нийт 300 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нэг жилийн хугацаатай 3 хувь хүүтэйгээр 44 ахуйн нэгжид 103.9 тэрбум төгрөгийг олгож, 5 тэрбум төгрөгийн хүүгийн татаасыг шийдвэрлэсэн.	70%
2	14.1.9. Боловсруулах үйлдвэрүүдэд байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи нэвтрүүлэх, импортыг орлох, экспортын баримжаатай үйлдвэрлэлийг дэмжих, тоног төхөөрөмж худалдан авах болон эргэлтийн хөрөнгийн зориулалттай хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг бий	2019 - 2020	МУХБ-103,900.0 сая төг, Гадаадын төслөөс-8,200.0 сая төг		-Боловсруулах үйлдвэрүүдэд байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи нэвтрүүлэх, импортыг орлох, экспортын баримжаатай үйлдвэрлэлийг дэмжих, тоног төхөөрөмж худалдан авах болон эргэлтийн хөрөнгийн зориулалттай хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор АХБ, Жайка ОУБ-ын төслүүдтэй хамтран ажиллаж байна. "Ноолуурын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээни тухай" Засгийн газрын 2020 оны 101 дүгээр тогтоолыг батлуулж, түүхий эдийн нөөц бүрдүүлэхэд шаардлагатай 200.0 тэрбум төгрөг, МУХБ-ны эх үүсвэрээр олгох зээлийн хүүгийн зөрүүд 30.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн. Нийт 44 аж ахуйн нэгжид 103.9 тэрбум ьгрөгийн зээлийг эргэлтийн хөрөнгөийн зориулалтаар олгосон.АХБ-ны Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн Нэмэлт санхүүжилт төслөөс 2020 онд 2 үйлдвэрт 8.2 тэрбум төгрөгийн зээлийг жилийн 7 хувийн хүүтэйгээр олгосон байна.	70%

	болгох шийдвэрийн төсөл боловсруулах б/ Санамж бичиг, гэрээ байгуулах					
3	14.1.10. Оюуны өмч, ирээдүйн бүтээгдэхүүнээр барьцаалан зээл авах боломжийг судлан хэрэгжүүлэх	2019 - 2020	УБ банк- 800.0 сая төг		Оюуны өмчийн газрын үйл ажиллагааг зохицуулсан хуулиудад нэмэлт болон шинэчилсэн найруулгыг төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулж байна. Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах тухай шинэ хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэхэд бэлтгэж байна. Эдгээр хуулийн төсөлд үнэлгээний олон улсын стандарт, Оюуны өмчийн үнэлгээ хийх мэргэжилтэн бэлтгэх, татвар хөнгөлөлт, чөлөөлөлт, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах сан байгуулах, гадаад улс оронд оюуны өмчийн бүтээлийн эрхийн хамгаалалт хийлгэхэд хууль эрх зүйн зөвлөгөө өгөх, оюуны өмчийн маргааныг шийдвэрлэх зэрэг асуудлуудыг тодорхой болгож өгсөн байна. -Оюуны өмчийн тэр дундаа Аж үйлдвэрийн өмчийн нэг төрөл болох барааны тэмдгийг барьцаалж зээл олгох үйлчилгээг Улаанбаатар хотын банк нэвтрүүлсэн. Одоогоор тус банк барааны тэмдгийг барьцаалж 50 хүртэлх сая төгрөгийн зээл олгож байгаа бөгөөд 2020 онд Улаанбаатар хотын банк барааны тэмдгийг барьцаалж 25 аж ахуйн нэгжид 800 гаруй сая төгрөгийн зээлийг аж ахуйн нэгж байгууллагад олгосон байна.	100%
4	14.1.11. Гадаад худалдааны эрсдэлээс хамгаалах даатгалын тогтолцоог нэвтрүүлэх боломжийг судлах	2019 - 2020	-		Нарийвчилсан тооцоолол болон Засгийн газрын баримталж буй бодлогод үндэслэн хоёр хувилбарыг харьцуулж үзсэний үр дүнд Сангийн яам зээлийн даатгалыг “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-д даатгаж, шууд бус үйлчилгээ үзүүлэх нь оновчтой гэсэн шийдвэрт хүрсэн. Гадаад худалдааны эрсдэлээс хамгаалах даатгалын тогтолцоог нэвтрүүлэх боломжийг судлах ажлын хүрээнд "Экспортыг дэмжих хөтөлбөр", "Үндэсний давхар даатгал" ХХК-тай хамтран Экспортын даатгалын тээвэрлэлтээс өмнө болон дараах 2 төрлийн бүтээгдэхүүнийг гаргахаар ажиллаж байна.	70%
5	14.1.12. Монгол экспорт хөтөлбөрийн төсөл боловсруулж	2019 - 2020	гадаад төслөөс 28.0 сая төг		ЗГ-ын 2018 оны 278 дугаар тогтоолоор "Монгол экспорт" хөтөлбөрийг батлуулах хэрэгжүүлж байна. “Экспорт Монгол 2020 олон улсын цахим форум, үзэгэлэн худалдаа” арга хэмжээг 2020 оны 12 дугаар сарын 18-нд цахим хэлбэрээр зохион байгуулсан. МУ-ын худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалт, экспортыг дэмжиж, тулгамдсан	100%

	батлуулах, хэрэгжилтийг хангах				асуудлуудыг хөндөж, тодорхой гарц шийдэл хайхаар дэлхийн өнцөг булан бүрээс жил бүр хуран чуулдаг тус Экспорт Монгол арга хэмжээ нь ийнхүү 6 дахь удаагаа зохион байгуулагдахдаа цахим хэлбэрээр зохион байгуулагдсан нь онцлог болсон юм. Төслийн зүгээс уг арга хэмжээнд дэмжлэг үзүүлж, хамтран зохион байгуулж ажилласан.Түүнчлэн, шинэлэг арга хэлбэрээр уламжлалт форум, үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, шинээр экспортын нэгдсэн сүлжээ бүхий платформыг нэвтрүүлэхэд: ГХЯ, ХХААХҮЯ, Соёлын яам, ҮХГ, ЗГХА-ЖДҮГ, МҮХАҮТ, Экспорт Олон Улсын Худалдааны Төв, USAID Best хөтөлбөр Хөгжлийн шийдэл ТББ, АНУ-ын ЭСЯ, АНУ-ын худалдааны яам, Амчам (AmCham), Европ Монголын Худалдааг дэмжих Трам төсөл зэрэг талууд хамтран ажиллаж, зохион байгуулсан.	
6	14.1.13. Үйлдвэрлэлийг дэмжих сангийн үйл ажиллагааг салбарын хөгжлийн бодлоготой уялдуулах, сангийн тогтвортой эх үүсвэрийг төсвийн хуульд тусган бүрдүүлэх арга хэмжээг авах	2019 - 2021	10.0 сая төг		2019 оны 02 дугаар сарын 27-ны өдөр Засгийн газрын тусгай сангуудын талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 87 дугаар тогтоолоор “Үйлдвэрлэлийг дэмжих сан”-г татан буулгасан. Үйлдвэрлэлийн дэмжих тухай хууль хүчингүй болсонтой холбогдуулан хууль эрх зүйг шинэчлэн боловсруулах шаардлага зүй ёсоор тавигдсан. Иймд Хөнгөн үйлдвэрийн тухай хуулийг санаачлан боловсруулж байгаа бөгөөд тандан судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Хуулийн үзэл баримтлалыг боловсруулах зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалтыг гүйцэтгэн зөвлөхийг шалгаруулсан байна. Боловсруулж буй хуулийн төсөлд үйлдвэрлэлийг дэмжих сан, түүхий эдийн сантай холбогдох заалтыг оруулахаар ажиллаж байна.	70%
7	14.1.15. Татварын багц хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж батлуулах	2018 - 2020	-		Татварын хуулийн шинэчлэлийг хэрэгжүүлж эхэлснээр нэг талаас жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжиж, бизнесийн орчныг сайжруулах замаар, нөгөө талаас татвараас зайлсхийх, зугтах явдлын эсрэг олон улсын туршлагаудыг нэвтрүүлэх замаар татварын бааз суурийг өргөжүүлнэ. Татварын ерөнхий хуулинд нэмэлт өөрчлөлт оруулан шинэчилсэн найруулгыг 2019 оны 3 сарын 22-нд УИХ-аас батлан гаргасан.	100%
8	14.1.17. ЗГ-ын 2015 оны 336-р тогтоолоор баталсан дотоодын	2018 - 2021	-		ЗГ-ын “Жагсаалт батлах тухай” 90 дүгээр тогтоолоор “Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалт”-ыг нэмэлт өөрчлөлт оруулан шинэчлэн баталсан.	100%

	үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах				Тогтоолоор 14 бүлгийн 175 нэр төрлийн бүтээгдэхүүнийг нэгтгэн батлуулсан.	
9	14.1.18. "Ерөнхий гэрээ байгуулах журам"-н дагуу ерөнхий гэрээнд хамруулах бараа үйлчилгээний судалгааг хийж, цахим дэлгүүрийн санд байршуулах	2019 - 2020	-		Төрийн худалдан авалтад нийлүүлдэг гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг Ерөнхий гэрээнд хамруулах судалгааг хийж, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль 2019 оны 5-р сарын 30-ны өдөр батлагдсантай холбогдуулан хүнсний худалдан авалтыг "Ерөнхий гэрээ байгуулах журам"-ын дагуу хийхээр шийдвэрлэсэн. СЯ-наас төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.5.7-д заасны дагуу ерөнхий гэрээнд хамруулах бараа, ажил, үйлчилгээг тодорхойлох зорилгоор судалгааны ажил хийсэн. БСШУСЯ, ТӨБЗГ-тай хамтран ерөнхий боловсролын сургууль дээр туршихаар загвар төсөл хийсэн. Туршилт хийх сургуулиудыг сонгосон, уг арга хэмжээ Ковид-19 цар тахлаас шалтгаалж хойшлогдоод байна.	70%
10	14.1.21. Үйлдвэрийн техник, технологийн чиглэлээрх үндэсний стандартыг боловсронгуй болгох, олон улсын дэвшилтэт стандартуудыг нутагшуулан нэвтрүүлэх ажлыг үргэлжлүүлэх	2019 - 2021	удсын төсөв-15.0 сая төг		1. Хөнгөн үйлдвэрийн салбарын 9 стандартыг шинээр болон шинэчлэн боловсруулав. Үүнд: оёмол бүтээгдэхүүний -2, ой модны үйлдвэрлэлийн -3, хэвлэл,хэвлэл, сав баглаа боодлын салбарын -2, гоосайхны салбарын -1, арьс ширний салбарын -1 стандартын төслүүдийг шинээр болон шинэчлэн боловсруулах ажлуудыг салбарын эрдэм шинжилгээний хүрээлэн, мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэж, стандартын төслийг СХЗГ-т хянан батлуулахаар хүргүүлсэн бөгөөд 2 стандартыг батлуулаад байна. 2. "ISO 9001-2015 Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо" стандартыг Мон-Ирээдүй" ХХК арьс шир боловсруулах үйлдвэр, "Бест Шүес" ХХК гутлын үйлдвэр, Дархан Нэхий ХК нэхий, арьс шир боловсруулах үйлдвэрүүдэд нэвтрүүлж, баталгаажуулалтын гэрчилгээг олгосон. - Органик болон байгалийн гаралтай гоо сайхны бүтээгдэхүүний орц найрлагад тавигдах шаардлагын тухай олон улсын ISO 16128 стандарт, ОУ-ын чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартыг гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэлд нэвтрүүллээ. - Олон	100%

				улсын MNS ISO/IEC17065 стандартын шаардлагыг бүрэн хангасан Монгол Улсын ноос ноолуурын салбарын “Тохирлын үнэлгээ-Бүтээгдэхүүн, үйл явц, үйлчилгээний баталгаажуулалт”-ыг явуулах эрх бүхий “Баталгаажуулалтын алба”-ыг байгуулсан. Монгол Улс ноолууран бүтээгдэхүүнээ “Монголын Хаан ширхэгт” чанарын тэмдэгээр баталгаажуулан эсспортонд гаргаж эхэлсэн.	
Зорилт 1-ийн дүн					85.0
14.2. Түүхий эд бэлтгэлийн тогтолцоог боловсронгуй болгож, түүхий эдийн нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлэх;					
11	14.2.1. Түүхий эд бэлтгэх, хадгалах, чанарыг хамгаалах, тээвэрлэх үе шатанд мөрдөх стандарт, арга зүй, үнэ цэнийн сүлжээг бий болгох чиглэлээр сургалт явуулах	2018 - 2021	-	“Түүхий эдийн ангилалтын загвар туршилт”-ыг явуулах арга зүйг “Бага насны ямааны ноолуурын ангилалт” “Хөх сарлагийн хөөврийн ангилалт” зэрэг 2 төрлийн түүхий эдийн онцлогт тохируулан боловсруулж, туршилтыг Хөвсгөл аймгийн Арбулаг, Алаг-эрдэнэ, Улаан-Уул сумдын малчдын 5 хоршоо, Жинст Мөрөн ХХК-тай хамтран зохион байгуулсан. Туршилтын явцад нийт 86 сургагч багшийг бэлтгэсэн ба сургагч багш нар “Түүхий эдийн чанар, ангилалт”-ын талаар сурсан мэдлэгээ нийт 350 гаруй малчдад зааж сургасан байна. “Бага насны ямааны ноолуурын ангилалт”-ын загвар туршилтад Улаан-уул сум хоршооноос 45 малчин өрх, Арбулаг сумаас 48, Алаг-эрдэнэ сумаас 25 буюу нийт 118 өрх хамрагдаж, ямааны ноолуурыг насаар ангилан ялгаж бэлтгээд хоршоогоор дамжуулан 3 тонн гаруй бага насны ноолуурыг бэлтгэн “Жинст Мөрөн” ХХК компанитай хийсэн гэрээний хүрээнд нийлүүлжээ. “Хөх сарлагийн хөөврийн ангилалт”-ын загвар туршилтад Улаан уул сумын хоршооноос 230 малчин өрх, Арбулаг сумаас 71, Алаг –эрдэнэ сумаас 442 буюу нийт 743 гишүүн малчин өрх хамтран ажилласны дүнд нийт 5 тонн гаруй хөөвөр бэлтгэснээс 1,5 тонн хөх сарлагийн хөөврийг өнгөөр нь тусгайлан ангилан бэлтгэж, тус компанид нийлүүлжээ. “Жинст Мөрөн” ХХК нь түүхий эдийн худалдан авалт, анхан шатны тордолт, хадгалах агуулах, тээвэрлэлт болон шаардагдах зардлын хариуцан ажиллаж байна. “Ангилж бэлтгэсэн түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх загвар туршилт”-ын хүрээнд “Жинст Мөрөн” ХХК нь ангилж бэлтгэсэн бага насны ноолуурын анхан шатны боловсруулалтыг “Өгөөж Шим” ХХК, ээрэхийг “Сноу филдс” ХХК, сүлжихийг “Мөнхбумууд” ХХК зэрэг компаниудтай кластераар	100%

					хамтран ажиллах түншлэлийн гэрээ байгуулан “Монголын хаан ширхэгт” бүтээгдэхүүний загвар гаргахаар хамтран ажиллаж байна.	
12	14.2.2. Орон нутагт түүхий эдийн гарал үүслийг баталгаажуулах лабораторийн чадавхийг сайжруулах	2018 - 2020	-		Лабораторийн сүлжээ цахим программ /www.vet.shinjilgee.mn/ 2016 оноос эхлэн бүх аймгуудад нэвтрүүлж, нийслэл болон бусад аймгуудын лабораториос малын өвчний оношлогоо, шинжилгээ түүхий эдийн гарал үүслийн шинжилгээг баталгаажуулан нэгдсэн мэдээлэлд оруулах нөхцөл бүрдүүлэв. ШХА-аас хэрэгжүүлсэн Ногоон алт-малын эрүүл мэнд төсөлд хамрагдсан Архангай, Говь-Алтай, Ховд, Завхан, Хөвсгөл, Төв зэрэг 6 аймгийн 15 сумын мал эмнэлгийн тасаг, нэгжийг дээрх цахим мэдээллийн системд холбох, мах, махан, сүү сүүн бүтээгдэхүүнд малын эмийн үлдэгдлийн шинжилгээ зөөврийн багаж, урвалж бодис нийлүүлж, эмч нарт ажлын байрны сургалт явуулав. Түүнчлэн мал, малын түүхий эдийн гарал үүслийг тодорхой болгох нэгдсэн бүртгэлд оруулах цахим технологи нэвтрүүлэх туршилт судалгааны ажлыг амжилттай гүйцэтгэв. Малын эрүүл мэндийн гарал үүслийн гэрчилгээний системийг орон нутаг, нийслэлд хэрэгжүүлж эхэлсэн нь ХХАА-н салбарт гхийгдэж буй томоохон ажлын нэг юм.	90%
13	14.2.3. Малын гаралтай түүхий эдийн гарал үүслийг тодорхойлох, бүртгэх, хянах тогтолцоог бий болгох, /мэдээллийн нэгдсэн сан, цахим сүлжээ/,	2019 - 2020	-		Малын эрүүл мэнд-Ногоон алт төслөөс МЭЕГ-тай хамтран Малын эрүүл мэндийн гарал үүслийн гэрчилгээний цахим системийг орон нутаг, нийслэлд хэрэгжүүлж эхэлсэн нь ХХАА-н салбарт хийгдэж буй томоохон ажлын нэг юм. Үүний үр дүнд эрүүл малын бүтээгдэхүүн мах, сүү, түүхий эд/ноос, ноолуур, арьс шир/-ийг боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, улмаар экспортод гаргах бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдэх боломжтой болсон.	70%
14	14.2.4. Түүхий эд бэлтгэх, чанарын хамгаалалт, тордолт хийх төвийг малчдын бүлэг, хоршооны үйл ажиллагаатай	2018 - 2020	-		“МХШ бүтээгдэхүүний чанарт нийцсэн түүхий эдээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хөгжүүлэх” загвар туршилтыг малчдын болон үйлдвэрлэлийн түвшинд хийгээд байна. “Түүхий эдийн ангилалтын загвар туршилт”-ыг явуулах арга зүйг “Бага насны ямааны ноолуурын ангилалт” “Хөх сарлагийн хөөврийн ангилалт” зэрэг 2 төрлийн түүхий эдийн онцлогт тохируулан боловсруулж, туршилтыг Хөвсгөл аймгийн Арбулаг, Алаг-эрдэнэ, Улаан-Уул сумдын малчдын 5 хоршоо, Жинст Мөрөн ХХК-тай хамтран зохион байгуулсан. Туршилтын явцад нийт	100%

	уялдуулан сумдад байгуулах				86 сургагч багшийг бэлтгэсэн ба сургагч багш нар “Түүхий эдийн чанар, ангилалт”-ын талаар сурсан мэдлэгээ нийт 350 гаруй малчдад зааж сургасан байна. “Бага насны ямааны ноолуурын ангилалт”-ын загвар туршилтад Улаан-уул сум хоршооноос 45 малчин өрх, Арбулаг сумаас 48, Алаг-эрдэнэ сумаас 25 буюу нийт 118 өрх хамрагдаж, ямааны ноолуурыг насаар ангилан ялгаж бэлтгээд хоршоогоор дамжуулан 3 тонн гаруй бага насны ноолуурыг бэлтгэн “Жинст Мөрөн” ХХК компанитай хийсэн гэрээний хүрээнд нийлүүлжээ. “Хөх сарлагийн хөөврийн ангилалт”-ын загвар туршилтад Улаан уул сумын хоршооноос 230 малчин өрх, Арбулаг сумаас 71, Алаг –эрдэнэ сумаас 442 буюу нийт 743 гишүүн малчин өрх хамтран ажилласны дүнд нийт 5 тонн гаруй хөөвөр бэлтгэснээс 1,5 тонн хөх сарлагийн хөөврийг өнгөөр нь тусгайлан ангилан бэлтгэж, тус компанид нийлүүлжээ. “Жинст Мөрөн” ХХК нь түүхий эдийн худалдан авалт, анхан шатны тордолт, хадгалах агуулах, тээвэрлэлт болон шаардагдах зардлын хариуцан ажиллаж байна. “Ангилж бэлтгэсэн түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх загвар туршилт”-ын хүрээнд “Жинст Мөрөн” ХХК нь ангилж бэлтгэсэн бага насны ноолуурын анхан шатны боловсруулалтыг “Өгөөж Шим” ХХК, ээрэхийг “Сноү Фиилд” ХХК, сүлжихийг “Мөнхбумууд” ХХК зэрэг компаниудтай кластераар хамтран ажиллах түншлэлийн гэрээ байгуулан “Монголын хаан ширхэгт” бүтээгдэхүүний загвар гаргахаар хамтран ажиллаж байна.	
15	14.2.6. Хөдөө аж ахуйн биржээр хийх арьс ширний туршилтын арилжаа хийх	2019 - 2021	-	ХХААХҮ-ийн Сайдын 2019 оны 11 дүгээр сарын 15-ний өдрийн А/409 тоот тушаалаар хөдөө аж ахуйн биржээр Арьс шир арилжих тушаалыг баталсан. ХААБ-ийн захирлын 2018 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн А/19 тоот тушаал, ЗГ-ын 2019 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 191 тоот тогтоолын хүрээнд “Их зам транс” ХХК, “Улаанбаатар мах экспо” ХХК, “New food century” ХХК-д агуулахын итгэмжлэл олгон биржийн Агуулахын бүртгэлийн програм суурилуулж, арилжаа төлбөр тооцооны санд бүртгэж, ажиллагааны зааварчилгаа өгөн туршилтын арилжааг эхлүүлсэн. 2019 оны 5 дугаар сарын 29-ны байдлаар 55,000 ширхэг стандартын шаардлага хангаагүй, боловсруулаагүй адууны ширийг биржийн арилжаагаар арилжиж, экспортолсон. 2021 онд хөдөө аж ахуйн биржээр 300000 ширхэг арьс арилжихаар төлөвлөсөн. 2020 онд ХААБ-ээр нийт 6944 тн ноолуурын арилжаа хийгдсэн байна.	100%	

16	14.2.8. Алслагдсан бүс нутагт элеватор барих /Сэлэнгэ аймагт 13.0 мян. тн үр тариа хадгалах, 2.0 мян. тн үрийн буудай хадгалах цогцолбор барих/	2019 - 2020	-		<p>Үр тариа хадгалах 23 элеваторын нийт багтаамж 523,0 мян.тн байгаагаас Хөдөө аж ахуйг дэмжих сангийн элеваторын багтаамж 182,0 мян.тн байна. Мөн үр тарианы аж ахуйн нэгжүүдийн үтрэмд үрийн болон аж ахуйн дотоодын хэрэгцээний үр тариа хадгалах агуулах, силосын нийлбэр багтаамж 269,5 мян.тн байгаа зэргийг математик аргаар тооцоолоход дотоодын ургацыг бүрэн хүлээн авч хадгалах боломжтой харагдаж байгаа боловч тариалангийн алслагдсан барүүн, зүүн бүсэд үр тариа хадгалах агуулахын хангамж дутагдалтай байна.</p> <p>Нийт элеваторын 90 хувь нь тариалангийн төв бүсэд байрлаж байгаагаас хамаарч тариалангийн баруун, зүүн бүсийн үр тариа тээврийн зай 350-1200 км хүртэл алслагдаж өөрийн өртөгт эзлэх тээврийн зардал өндөр байна.</p> <p>2019 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Оросын холбооны улсын аж үйлдвэр, худалдааны яам хоорондын санамж бичиг байгуулсан.</p> <p>Тус санамж бичигтэй уялдуулан тариалангийн баруун зүүн бүсэд тус бүр 10,0 мян.тн багтаамжтай үр тарианы элеваторийг байгуулахаар шийдвэрлэж, тус элеваторын суурь байгуулах санхүүжилт болох 4.5 тэрбум төгрөгийг 2021 оны улсын төсөвт суулгаж, барилга байгууламжийн санхүүжилт /угсралт/-ийг ОХУ-ын талаас хийхээр харилцан тохиролцсон.</p> <p>Элеваторийг Увс аймгийн Баруунтуруун, Сүхбаатар аймгийн Түмэнцогт суманд тус бүр 10.0 мянган тонн багтаамжтай үр тариа хадгалах зориулалттайгаар зураг төсөл, газрын асуудлыг 2020 онд шийдвэрлэн бэлэн болгосон.</p>	70%
17	14.2.9. Төв, суурин газрыг түшиглэн зоорь, агуулах байгуулах	2019 - 2020	-		<p>Монгол Улсын Төсвийн 967.819.330.0 /Есөн зуун жаран долоон сая найман зуун арван есөн мянга гурван зуун гуч/ төгрөгийн санхүүжилтээр Хүнсний ногооны зоорь /Ховд аймгийн Жаргалант сум/ байгуулах түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй 2018 оны 08</p>	70%

					<p>дугаар сарын 13-ны өдрийн ТШ-УТ-ХНЗ-ХОВД-1 дугаартай төмс, хүнсний ногооны механикжсан 1000 тонн багтаамжтай агуулахыг Ховд аймгийн Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/580 тоот захирамжаар байгуулсан Хүнсний ногооны зоорийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс үзэж, зоорийг 2020 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 02 тоот комиссын тэмдэглэл үйлдэж, Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/2020 тоот дүгнэлтээр бүрэн хүлээж авсан. Монгол Улс - БНПУ-ын Засгийн газар хооронд Монгол Улсад “Хүнсний ногооны үйлдвэрлэлд нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх” 10.2 сая еврогийн санхүүжилттэй төслийг хэрэгжүүлнэ. Төслийг А. Багц 1. Төмс, хүнсний ногооны агуулах байгуулах. Төсөв нь 7.0 сая еврогоор 5аймаг, Нийслэлд нийт 6 байршилд 8500 тонн багтаамжтай сүүлийн үеийн дэвшилтэд технологи бүхий төмс, хүнсний ногооны агуулахыг байгуулахаар шийдвэрлэсэн. Б.Багц 2. Хүнсний ногооны үйлдвэрлэлд зориулсан трактор,техник тоног төхөөрөмж нийлүүлэх. Төсөв нь 3.2 сая евро хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Ковид-19 цар тахалтай холбогдуулан Польшийн талаас тус төслийг батлах ажил удааширалттай явагдаж байгаа ба 2020 оны 12 дугаар сард багтаан Польш улсын тал батлахаар ажиллаж байгаа тухай тус улсын Элчин сайдын яамнаас мэдээлсэн.</p>	
					Зорилт 2-ын дүн	85.7%
<p>14.3. Боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, орон нутагт үйлдвэрүүд байгуулах, жижиг, дунд үйлдвэрийг кластераар хөгжүүлэх замаар нэмүү өртөг шингэсэн, өрсөлдөх чадвартай, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;</p>						
18	14.3.1. Эмээлтийн үйлдвэр технологийн паркийн дэд бүтцийг байгуулах	2019 - 2020	Нийслэлийн төсөв-400.0 сая төг		<p>Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн ҮТП-ийн дэд бүтцийг байгуулах ажлын хүрээнд Паркийн Үерийн барилга байгууламжийн ажлын зураг төсөл /9км/, Цахилгаан хангамжийн ажлын зураг төсөл /110/35/10 дэд өртөө, Технологийн усан хангамжийн ашиглалтын цооног гаргах ажил, Барилга угсралтын үеийн цахилгаан хангамжийн ажлуудыг тус тус хийж гүйцэтгээд байна. Тус газраас 2020 онд дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд: Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн ҮТП-ийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтад шаардлагатай санхүүжилтийг Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тодотголд, 2021 оны Улсын төсвийн хөрөнгө</p>	30%

				<p>оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад тусгуулахаар тус тус саналаа боловсруулж хүргүүлсэн. Тус паркийн ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулах ажлын санхүүжилтийг шийдвэрлэх асуудлаар Дэлхийн банк, Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн ҮТП, НШУҮИГ-ын төлөөллүүд оролцсон гурвалсан уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Паркийн ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулах асуудлаар Дэлхийн банкны санхүүжилтээр хийлгэхээр урьдчилсан байдлаар хэлэлцэгдэж байна. НЗДТГ-аар дамжуулан Сангийн яамнаас дэмжлэг хүссэн албан хүсэлт хүргүүлээд байна. Паркийн төслийн магадлалын шинжилгээ, байгаль орчны үнэлгээний 400.0 /дөрвөн зуун/ сая төгрөг Нийслэлийн 2020 оны төсөвт шилжин батлагдаж, “Паркийн төслийн магадлалын шинжилгээ, байгаль орчны үнэлгээ”-ний ажлын гүйцэтгэгчээр Ди Ди Эй Жи ХХК шалгаран гэрээ байгуулан ажиллаж байна. /Цаашид Эмээлтийн ҮТП-ын дэд бүтцийн бүтээн байгуулалтад нийт 479,1 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай байгаагаас паркийн ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулахад 2 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай байна./</p>	
19	14.3.2. Налайхын ҮТП-ийн дэд бүтцийг байгуулах	2019 - 2020	Нийслэлийн төсөв-7,500 сая төг	<p>НИТХТ-ийн 2020 оны 93 дугаар тогтоолоор Налайхын “Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк”-ийн цэвэрлэх байгууламжийг барих төслийг “Нийслэлийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д нэмэлт өөрчлөлт оруулан баталсан. БХБЯ-ны Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газартай паркийн цэвэрлэх байгууламжийн санхүүжилтийн тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцэж, Засгийн газрын хуралдаанаар паркийн цэвэрлэх байгууламжийн санхүүжилтийг хэлэлцүүлэхээр холбогдох материалыг тус тус хүргүүлсэн. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, АХБ-ны суурин төлөөлөгчийн газрын хүмүүстэй хамт паркийн үйл ажиллагаатай танилцаж, цэвэрлэх байгууламжийн санхүүжилтийг шийдвэрлэх талаар хэлэлцэж, паркийн цэвэрлэх байгууламжийн зураг төсвийг АХБ-ны суурин төлөөлөгчийн газарт хүргүүлэн, хамтран ажиллаж байна. Паркийн цахилгаан хангамжийн эхний ээлжийн бүтээн байгуулалт 110 кв-ын дэд станц, удирдлагын байрыг барих ажилд 3,2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Нийслэлийн төсвөөс шийдвэрлэж, эхний ээлжийн бүтээн байгуулалт 110 кв-ын дэд станцын барилгын ажил дуусаж, тоног төхөөрөмжийг суулгах ажил</p>	70%

					хийгдэж байна. Мөн паркийн цахилгаан хангамжийн 2 дугаар ээлжийн барилга угсралтын ажилд 2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Нийслэлийн төсвөөс шийдвэрлэж, ажлын гүйцэтгэл 70% тай хийгдэж байна. Паркийн Налайх-Чойрын чиглэлийн төв замд холбох 4,64 км авто замын бүтээн байгуулалтын ажилд 2020 оны Нийслэлийн төсвөөс 5,5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж, 4.64 км авто замын хучилтын ажил болон явган хүний замын тохижилтын ажил 100% хийгдэж дууссан. Паркийн үерийн хамгаалалтын барилга байгууламжийг барьж байгуулах ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэн 100% дуусгаж, Улсын комисст хүлээлгэн өгөх саналыг хүргүүлсэн.	
20	14.3.4. Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлэх	2019 - 2021	-		Багануур дүүрэгт “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” байгуулах ажлын хүрээнд 854.7 сая төгрөгөөр паркийн ХЕТ, дэд бүтцийн зураг төслийг боловсруулж, нарийвчилсан үнэлгээ болон паркийн оффисын зураг төслийг боловсруулах ажлыг эхлүүлсэн. Паркийн хүнд үйлдвэрлэлийн бүсийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын 20,1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн тодотголд тусгуулахаар саналаа боловсруулан хүргүүлсэн. Паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл экспертээр магадлал хийгдэн, дулаан хангамж, мэдээлэл холбооны ажлын зураг баталгаажсан. Ус хангамж ариутгах татуургын ажлын зураг төсөл дууссан, цахилгааны техникийн нөхцөл гарсан. Паркийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажил хийгдэж дууссан. /Хүнд үйлдвэрийн бүсийн дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд одоогоор ашиглалтгүй байгаа Багануурын уурхайн төмөр замын хөрс тээвэрлэлтийн станцын барилга байгууламжийг паркийн дэд бүтцэд ашиглах боломжтой байгаа тул холбогдох шийдвэрийг гаргуулахаар дээд шатны байгууллага руу саналыг хүргүүлсэн./ Паркт нэн тэргүүнд шаардлагатай ерөнхий цахилгаан хангамжийн 110 кВт-ын агаарын шугамын эхний ээлжийн 7.3 км шугамыг “МЕСЕС” ХХК-ийн хөрөнгө оруулалтаар хийхээр гэрээ байгуулан, ЭХЯ-наас шинэчилсэн техникийн нөхцөлийг баталгаажуулсан. Одоогоор цахилгаан хангамжийн 110 кВт-ын агаарын шугамын зураг төслийг “Мон-Энержи” ХХК боловсруулан ажлын гүйцэтгэл 70%-тай хийгдэж байна. Мөн паркийн үйлдвэрийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, техник технологийн түвшний үнэлгээний	50%

					судалгаа, шинжилгээний ажлуудыг хийж дуусган, мэдээллийн санг бүрдүүлсэн. Паркийн гадна болон дотоод дэд бүтэц, нийтийн барилга байгууламжуудыг 2021-2025 онуудад бүтээн байгуулах хөгжлийн 2 дахь шатны Стратеги төлөвлөгөөг боловсруулан батлуулаад байна.	
21	14.3.5. Хөтөлбөрийн баримт бичигт байгаль орчны стратегийн үнэлгээ хийлгэх, байгаль хамгаалах ногоон хөгжлийн зорилтыг хангах, нөлөөлөлд өртөх байгалийн нөөц, экосистем, хүн амын эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэл сөрөг нөлөөллийг тодорхойлох	2019 - 2020	-		Сайдын зөвлөлийн 2020 оны 05 сарын 11-ний өдрийн хурлаар Сүхбаатар хөгжил үйлдвэрлэл, технологийн парк, “Шинэ Ховд үйлдвэрлэл, технологийн парк” ХХК, “Зуунмод парк” ХХК, Баганхангайн үйлдвэрлэл, технологийн паркуудад үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох асуудлыг хэлэлцүүлэн Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10.2-т заасны дагуу баримт бичгийн бүрдлийг хангаж Засгийн газрын хуралдаанд өргөн барихаар шийдвэрлэсэн. Засгийн газрын 2020.06.12-ний өдрийн хуралдаанаар Шинэ Ховд үйлдвэрлэл, технологийн парк” ХХК, “Зуунмод парк” ХХК-д Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Эрдэс плазм ХХК - иас ирүүлсэн хүсэлтийн дагуу шилний үйлдвэрийн парк байгуулах асуудлыг судлан үзэж үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ирүүлэх талаар санал хүргүүлсэн. Мөн тус компанийн удирдлагыг хүлээн авч уулзан хамтран ажиллах талаар санал солилцсон. Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 10 сарын 20-ны өдрийн зөвлөлийн хурлаар Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилт, тусгай зөвшөөрлийг олгох талаар хэлэлцүүлсэн. Тус хурлаар Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл гарсан Ховд, Зуун мод үйлдвэрлэл, технологийн паркуудад тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгохоор шийдвэрлэсэн.	90%
22	14.3.6. Орон нутгийн онцлог, нөөцөд суурилан дэвшилтэт технологитой, өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрүүдийн	2019 - 2020	-		Хүнсний эслэг ихээр агуулсан жимсний хальс, навч, хүнсний ногоо, ургамал, жимс жимсгэнэ зэрэг эх орны түүхий эдийн шинэ нөөц ашиглан хийх "Эрүүл мэндэд чиглэсэн импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэл" зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалт зохион байгуулж, ТЭЗҮ-ийг боловсруулсан. Уг тайланд эрүүл мэндэд чиглэсэн найрлага бүхий эх орны түүхий эдийн шинэ нөөц ашиглалт, технологийн тооцоо, үйлдвэрийн зардал, эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын тооцоо, тоног төхөөрөмжийн байршлын болон ерөнхий төлөвлөлтийн	100%

	ТЭЗҮ, зураг төсвийг хийх				зураг зэргийг тусгасан бөгөөд энэхүү жишиг ТЭЗҮ-ийн дагуу ундаа, шүүсний үйлдвэр байгуулах боломж бүрдсэн. Ингэний сүү боловсруулах үйлдвэрийн байршил, газар, дэд бүтцийг шийдвэрлүүлж, үйлдвэрийн зураг төсвийн ТЭЗҮ-ийг "Монгол тэмээ корпораци" ХХК-иар орон нутгийн төсвөөр гүйцэтгүүлсэн. "Хүүхдийн сүүний үйлдвэр байгуулах" зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалт зохион байгуулж, ТЭЗҮ-ийг боловсруулсан. "Цэвэр өсгөврийн хөрөнгө үйлдвэрлэх" зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалт зохион байгуулж, ТЭЗҮ-ийг боловсруулсан. ТЭЗҮ боловсруулснаар үйлдвэр байгуулах зардал, технологийн тооцоо, эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын тооцоо, тоног төхөөрөмжийн тооцоо, байршлын болон ерөнхий төлөвлөлтийн зураг зэргийг тусгаснаар үйлдвэр байгуулах боломж бүрдсэн.	
23	14.3.7. Орон нутаг, нийслэлд 100-аас доошгүй үйлдвэрийг шинээр барьж байгуулах, шинэчлэхэд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх	2018 - 2021	ЖДҮХС-750.0 сая төг Хувийн хэвшил-2,800.0 сая төг Бусад-440.0 сая төг		Хөтөлбөрийн үр дүнд: Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хэмжээ 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 12 хувьд хүрч, арьс, ширэн түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин 41 хувь, ноос, ноолууран түүхий эдийн бүрэн боловсруулалтын түвшин 26 хувь, нийт 81 үйлдвэр байгуулагдаж 4100 орчим ажлын байр бий болсон байна. "Ковид-19" цар тахлаас шалтгаалан хөрөнгө оруулалт болон зээл тусламж хязгаарлагдмал болсон, мөн шинээр байгуулагдаж байгаа болон шинэчлэгдэж буй үйлдвэрүүдийн тоног төхөөрөмжүүдийг импортоор оруулж ирэх, угсралт, засвар үйлчилгээ хийх мэргэжилтэн ажилтан ажиллуулах зэрэгт тодорхой хэмжээний хүндрэлүүд үүсч байсан тул 2020 онд шинээр үйлдвэрүүд байгуулах ажил төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна.	70%
24	14.3.9. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 30-аас дээш хувийг экспортод гаргаж байгаа үйлдвэрүүдэд олгосон зээлийн хүүгийн зөрүүг олгох ажлыг зохион байгуулах	2019 - 2021	5,100. сая төг		Хөнгөн үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх, үндэсний үйлдвэрүүдийг чанартай түүхий эдээр хангах, ажлын байрыг бууруулахгүй байх, экспортыг дэмжих зорилгоор Засгийн газрын 2020 оны "Ноолуурын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 101 дүгээр тогтоолыг батлуулсан. Зээлийн хүүгийн хөнгөлөлтийг санхүүжүүлэх гэрээ болон Аж ахуйн нэгжтэй бодлогын гэрээ байгуулахыг ТНБД зөвшөөрсөн "Гэрээ байгуулах эрх олгох тухай" ХХААХҮ-ийн сайдын 2020.03.26. А/115 тоот тушаал батлуулав. Ноолуур бэлтгэх зорилгоор нийт 44 аж ахуйн нэгжид 103,9 тэрбум төгрөгийн зээлийг МУХБ болон арилжааны банкуудаар дамжуулан олгосон. Тус яамнаас дээрх зээлийн	90%

					хүүгийн зөрүү 9 хувийн хүү болох 5.1 тэрбум төгрөгийг 2020 онд олгоод байна.	
25	14.3.12. Салбарын хөгжил, нийгэм эдийн засгийн ач холбогдол бүхий шинжлэх ухаан, технологийн болон инновацийн төслүүдийн үр дүнг үйлдвэрлэгчдэд мэдээлэх, түгээх	2019 - 2021	-		Салбарын хөгжил, нийгэм эдийн засгийн ач холбогдол бүхий шинжлэх ухаан, технологийн болон инновацийн төслүүдийн үр дүнг үйлдвэрлэгчдэд мэдээлэх, түгээх ажлыг 2020 оны хувьд цахим хэлбэрээр зохион байгуулан ажилласан. - Мон-Ирээдүй” ХХК арьс шир боловсруулах үйлдвэр, “Бест Шүес” ХХК гутлын үйлдвэр, Дархан Нэхий ХК нэхий, арьс шир боловсруулах үйлдвэрүүдэд "ISO 9001-2015 Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо” стандартын баталгаажуулалтын гэрчилгээ гардуулах ёслолын арга хэмжээг 10 дугаар сарын 21-ны өдөр ХХААХҮЯ-нд зохион байгуулсан. - Органик болон байгалийн гаралтай гоо сайхны бүтээгдэхүүний орц найрлагад тавигдах шаардлагын тухай ОУ-ын ISO 16128 стандарт, ОУ-ын чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартыг тус тус нэвтрүүллээ. Монголд үйлдвэрлэсэн 90-ээс дээш хувийн байгалийн гаралтай орц найрлага бүхий 100 гаруй гоо сайхны бүтээгдэхүүний цахим худалдааны сайтыг ажиллуулахад бэлэн болсон. - Олон улсын MNS ISO/IEC17065 стандартын шаардлагыг бүрэн хангасан Монгол Улсын ноос ноолуурын салбарын “Тохирлын үнэлгээ-Бүтээгдэхүүн, үйл явц, үйлчилгээний баталгаажуулалт”-ыг явуулах эрх бүхий “Баталгаажуулалтын алба”-ыг байгуулсан. Монгол Улс ноолууран бүтээгдэхүүнээ “Монголын Хаан ширхэгт” чанарын тэмдэгээр баталгаажуулан эскпортонд гаргаж эхэлсэн.	90%
26	14.3.13. Иновацийг дэмжиж үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуулиудтай хамтран ажиллах	2019 - 2021	26.0 сая төг		- "Хөнгөн үйлдвэрийн салбарын шинжлэх ухаан, хөгжлийн стратеги, экспортын чиг хандлага" сэдэвт эрдэм шинжилгээ, онол практикийн хурлыг ХААИС, ШУТИС-тай хамтран 2020.10.16-ны өдөр зохион байгуулсан. Тус хуралд салбарын эрдэмтэн судлаач, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудын нийт 80 орчим хүнийг хамруулсан. Хурлаас гарсан санал зөвлөмжийг нэгтгэн Ерөнхий сайдад хүргүүлэхээр ажиллаж байна. - Мөн Засгийн газрын тогтоолоор Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийг шинээр байгуулан ажиллаж байна. - МУБИС-ийн “Ургамлын судалгаа, сургалт арга зүйн төв”-тэй хамтран “Гоо сайхны бүтээгдэхүүний түүхий эдийг бэлтгэх, үйлдвэрлэх, экспортлох чиглэлийн судалгаа”-ны ажлыг, ШУТИС-ын "Ой модны сургалт судалгааны хүрээлэн"-тэй хамтран “Нийслэлийн мод, модон түүхий эдийн бэлтгэлийн цогц	100%

					судалгаа”-ны ажил, “Монгол гэр. Техникийн ерөнхий шаардлага” багц стандартыг шинэчлэн боловсруулах ажлуудыг гүйцэтгэв.	
27	14.3.15. Арьс ширний үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, технологи дамжуулах төв байгуулах	2019 - 2020	-		ЗГ-ын 2020 оны “Төрийн өмчит үйлдвэрийн газрын талаар авах зарим арга хэмжээний тухай” “Хөнгөн үйлдвэрийн судалгаа, туршилт, үйлдвэрлэл, бизнесийн корпораци” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв” улсын төсөвт үйлдвэрийн газрыг нийлүүлэх замаар “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрыг байгуулж, хавсралтаар дүрмийг баталсан. “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн төв” нь механик цехийг сэргээн засварлаж “Арьс ширний үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, технологи дамжуулах төв”-тэй болохоор бизнес төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.2. БСШУЯ-ны харьяа Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэнд Металл, машин судлалын салбар ажиллаж байна. Металл, машин судлалын салбар нь Машин тоног төхөөрөмж зохион бүтээх, турших, үйлдвэрлэх, суурилуулах, засварлах зэрэг үйл ажиллагаа явуулдаг. Хөдөө орон нутагт арьс шир, ноос боловсруулах өрхийн болон жижиг, дунд үйлдвэрийн 20 гаруй төрлийн 620-иод машин, тоног төхөөрөмжийг зохион бүтээж, туршин үйлдвэрлэж нийлүүлээд байна. Үүний зэрэгцээ тус хүрээлэнгийн Үслэг арьс боловсруулах туршилт үйлдвэрлэлийн цехийн технологийн бүх машин, тоног төхөөрөмжийг зохион бүтээж, “Ноосон дулаалга” Гарааны компани болон “Арьс шир боловсруулах өндөр технологийн инкубатор”-ын туршилт-үйлдвэрлэлийн цехүүдийн машин, тоног төхөөрөмжүүдийг угсарч суурилуулан, тохируулж, зарим тоног төхөөрөмжийг үйлдвэрлэн, байр болон дэд бүтцийн хамт ажилд бэлэн болгон хүлээлгэн өгч, засвар үйлчилгээг хийн хамтран ажиллаж байна.	70%
28	14.3.18. Франчайзинг нэвтрүүлэх олон улсын зөвлөгөөнд оролцох, үйлдвэрлэлд нэвтрүүлэх инновацийг	2018 - 2021	-		Франчайзинг нэвтрүүлэх боломжтой, сонирхогч салбар, үйлдвэрийн судалгааны хүрээнд жил бүр зохион байгуулагддаг Олон улсын франчайзингийн олон улсын зөвлөгөөнд оролцсон. Франчайзинг нэвтрүүлэхээр Дархан -Уул аймгийн арьс ширний гүн боловсруулах, ноос ноолуурын зэрэг үйлдвэрүүдийг хөгжлийн загвар үйлдвэрт тодорхойлоод байна. Тус аймагт арьс ширний гүн боловсруулах хөгжлийн загвар франчайзинг үйлдвэр байгуулах чиглэлээр Европын Холбооны Улсын Бельги, Итали, Герман зэрэг улсын туршлага судлан	100%

	тодорхойлох, хэрэгжүүлж эхлэх				<p>үзэсгэлэнд оролцож энэ талаар Италийн арьс ширний ACCOMAK холбоотой хамтран ажиллахаар тохиролцов. • Монпеллетс” ХХК нь франчайзинг нэвтрүүлж монгол хурганы болон ахрын ноосоор био бордоо үйлдвэрлэн Берлин хотын Хумболдын Их сургуультай 2005-2007 онд хамтран технологи инновацийн бүтээгдэхүүн гаргасан. Төв аймгийн Эрдэнэ суманд орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмж суурилуулж, үйлдвэрээ 2018 оны 9-р сард байгуулан, Герман Япон, Солонгос болон дотоодын зах зээлд нийлүүлж байна. Уг бордоо нь экологийн цэвэр бүтээгдэхүүнээс гадна ургацыг 2-3 дахин нэмэгдүүлдэг, баруун Европ, Азийн зарим оронд экспортод гардаг, зах зээлийн өндөр үр ашигтай инновацийн бүтээгдэхүүн болоод байна. • Дараахь үйлдвэрүүд нь шинэ технологи нэвтрүүлж инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Үүнд: Уламжлалт үндэсний монгол дээлийг орчин үеийн нано технологиор гарган авсан гал болон ус нэвтэрдэггүй материалаар “Хадлан” дээлийг “Three flames” ХХК ны загвар зохион бүтээгчид бүтээн, инновацийн эрэлт өндөр бүтээгдэхүүн болоод байна. Дотоод зах зээлээс гадна АНУ, Герман, Францад эрэлттэй, борлуулалт өндөр бүтээгдэхүүн болсон. Дархан-Уул аймгийн УГТЭШХ-нд “Гарааны био ундарга” ХХК-ий “Ризо” шингэн бордооны үйлдвэр байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхэллээ. Шингэн бордооны хувьд ашиглаж, түгээхэд хялбар, үр дүн сайтай. Уг бордоог ашигласнаар үрт ургамлуудыг 10-20 хувь, төмсийг 15-25 хувь, улаан лооль, өргөст хэмх зэрэг нарийн ногоог 20-40 хувь хүртэл ургацыг нэмэгдүүлэх боломжтой.</p>	
29	14.3.19. Соёлын болон бүтээлч аж үйлдвэрлэлийн үзэсгэлэн зохион байгуулах, сурталчилгаа хийх, төрийн худалдан авалтаар дэмжих, төсөл боловсруулах	2019 - 2021	-	<p>ГХА Соёл, урлагийн газраас 2019 онд зохион байгуулсан "Орчин үеийн соёлын илэрхийллийн олон төрөл болон бүтээлч үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих нь" Үндэсний зөвлөлдөх уулзалтад оролцож, соёлын болон бүтээлч үйлдвэрийн өнөөгийн байдал, Юнеско-ийн 2005 оны "Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхүүлэн дэмжих тухай" конвенцын үндсэн баримт бичгүүдтэй танилцан, 4 салбар хуралдааны Соёлын болон бүтээлч үйлдвэрлэл ба жендер сэдэвт хэлэлцүүлэгт оролцон санал солилцов. - Дотоодын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг борлуулах зорилгоор “Улаанбаатар түншлэл-2020” Олон улсын үзэсгэлэн худалдаа, "Монгол экспорт экспо-2020" дотоодын үзэсгэлэн худалдааг 2020 оны 9, 10 сард тус тус зохион байгуулав. Үзэсгэлэн худалдаанд хөнгөн үйлдвэрийн салбарын 218</p>	100%	

					<p>үйлдвэрлэгчид оролцож, 550 гаруй сая төгрөгийн борлуулалт хийсэн. Үзэсгэлэнгээр нийт давхардсан тоогоор 6000 гаруй хүн очиж сонирхон худалдан авалт хийсэн байна. Мөн "Экспорт монгол 2020" Олон улсын цахим форум, сургалт, виртуал үзэсгэлэнг ГХЯ, ҮХГ, Экспорт олон улсын худалдааны төв ТББ-тай хамтран 2020 оны 12 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан цахим үзэсгэлэн худалдаанд хөнгөн, хүнсний салбарын нийт 43 ААН 200 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүнээр оролцсон бөгөөд 10 гаруй орноос давхардсан тоогоор 24000 гаруй удаагийн хандалт хийж, сайтад байршуулсан ААН-ийн материалуудаас 200 гаруй материалыг татаж авсан байна. Нийт арга хэмжээний хүрээнд https://www.expromongolia.org/ хаягаар АНУ, Япон, Австри, ХБНГУ, Франц, ОХУ, БНХАУ, Их Британи, Сингапур, Вьетнам, Болгар, Чех, Польш, БНСУ зэрэг 20 орчим улсын 360 гаруй, дотоодын 1600 гаруй оролцогч бүртгүүлэн оролцсон бөгөөд бусад олон нийтийн сүлжээ, цахим хуудсаар 6400 гаруй удаагийн хандалт хийсэн байна.</p>	
30	14.3.20. Үйлдвэрүүдэд үндэсний түүх, соёлын онцлогтой шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож сургалт зохион байгуулах	2019 - 2021	-		<p>Урбан брэндийн Хүрээ коллекц: Монголын нууц товчоонд гардаг Бөртэ чоно, Гоо маралын домгоос гадна ариун нандин хайрыг хаан бугуйвч, хатан сүйхээр төлөөлүүлэн, бат бэх, эрүүл энхийг ханан хээгээр бэлгэдэн, эрдэм ном, элбэг баяныг зоосон хээгээр загвартаа тусгалаа. Ингэснээр уламжлалт үндэсний хувцаснууд маань илүү загварлаг, трендлэг биед эвтэйхэн, таатай байдлыг бүрдүүлэх боломжтой болсон. Монгол уламжлалт гэрийн ерөнхий архитекторыг орчин үеийн майхан хэлбэрт оруулан инновацийн бүтээгдэхүүн болгон, гадаад зах зээл дээр хөрөнгө оруулах маркетинг хийж, бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийж буй ГЭР ТЕНД ХХК экспортын үйлдвэрлэл явуулж, гадаад орны захиалга авч үйлдвэрлэж байна.</p>	100%
31	14.3.22. Эрчим хүчээр хангах бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэхэд холбогдох яамтай хамтарч ажиллах	2019 - 2021	-		<p>Үйлдвэржилт 21:100 хөтөлбөрт туссан томоохон бүтээн байгуулалтын ажлуудад ХХААХҮЯ-аас Барилга, хот байгуулалтын яам, Эрчим хүчний яам, болон бусад холбогдох орон нутгийн төрийн байгууллагуудтай хамтран бодлого арга зүйн болон хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэн ажилласан. Тухайлбал “Дархан арьс ширний цогцолбор” Үйлдвэрлэл технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад тус яам холбогдох төрийн байгууллагуудтай хамтран ажилласан бөгөөд нийт дэд бүтцийн бүтээн байгуулалт 2020</p>	100%

					оны эцсийн байдлаар 22.9 хувь, үүнээс цахилгаан түгээх, хангах сүлжээ, дэд станцын бүтээн байгуулалт 57.2 хувьтай байна. Хөвсгөл аймагт байгуулагдаж буй “Ой модны цогцолбор үйлдвэр” байгуулах ажлын хүрээнд цогцолбор үйлдвэрийн байршлын газрын зөвшөөрлийг аван, хашаажуулан, эрчим хүчний шугам татан ашиглалтад оруулсан. Цар тахлын сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 211 дугаар тогтоолоор хөнгөн үйлдвэрийн салбарын нийт үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр хураамжийг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс тооцож 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд төрөөс хариуцан төлөх арга хэмжээг зохион байгуулсан.	
Зорилт 3-ын дүн					89.2%	
14.4. Боловсруулах үйлдвэрийн хөгжлийн чиг хандлага, эрэлтэд нийцүүлэн хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах, ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;						
32	14.4.2. Боловсруулах үйлдвэрийн салбарын ажиллах хүчийг бэлтгэх, сургах, давтан сургах арга хэмжээг МСҮТ-үүдийг түшиглэн зохион байгуулах	2019 - 2021	-		БСШУС-ын сайдын 2016 оны А/150 дугаар тушаалаар баталсан мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад бэлтгэх мэргэжлийн чиглэл, индексийг шинэчлэн батлуулах ажлын хүрээнд ХНХЯ, ШУТИС-ын ҮТС-ийн эрдэмтэн судлаачид, салбарын мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгжүүдийн 30 гаруй төлөөллийг хамруулан 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр ХХААХҮЯ-ны 1 давхрын хурлын танхимд санал солилцох уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтаас гарсан санал болон мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагууд, мэргэжлийн холбоод, ажил олгогчдоос ирүүлсэн саналыг нэгтгэн, Хөнгөн үйлдвэрийн салбарын мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад бэлтгэх мэргэжлийн чиглэл, индексийн саналыг “Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт-08-д нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх саналын маягт”-ын дагуу боловсруулж цаашид тус чиглэлээр сургалтуудыг зохион байгуулахаар боллоо.	50%
33	14.4.3. "Мэргэжилтэй ажилтан" хөтөлбөрийг боловсруулах ажлыг "Ажилсаг Монгол"	2018 - 2020	-		“Мэргэжилтэй ажилтан үндэсний хөтөлбөр”-ийн төслийг ЖДҮҮХХБЗГ-тай хамтран боловсруулж, яамны холбогдох газар, хэлтсүүдээс тусгах саналыг авч нэгтгэн, ажлын хэсгийн хүрээнд хөтөлбөрийн төслийг хэлэлцүүлж, саналыг тусгасан. 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт,	50%

	хөтөлбөртэй уялдуулан нэгтгэн зохион байгуулах				түүний удирдлагын тухай хуульд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн дунд хугацааны баримт бичиг буюу 10 жилийн хугацаанд хэрэгжих Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг тогтоосноор “Мэргэжилтэй ажилтан үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулж, батлуулах эрх зүйн үндэслэлгүй болсон. Ажлын хэсгээс гаргасан саналын дагуу Монгол Улсын Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тус ажлыг өөрчлөн тусгуулахаар санал хүргүүлсэн. - ХНХЯ-аас мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад бэлтгэх мэргэжлийн чиглэл, индексийг шинэчлэн боловсруулж байгаатай холбогдуулан ХНХЯ, ШУТИС-ын ҮТС-ийн эрдэмтэн судлаачид, салбарын мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгжүүдийн 30 гаруй төлөөллийг хамруулан 10 дугаар сарын 23-ны өдөр ХХААХҮЯ-ны 1 давхрын хурлын танхимд санал солилцох уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтаас гарсан саналыг нэгтгэн “Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт-08-д нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх саналын маягт”-ын дагуу Хөнгөн үйлдвэрийн салбарын мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад бэлтгэх мэргэжлийн чиглэл, индексийг нэгтгэн боловсруулж, БТГ-т хүргүүлсэн.	
34	14.4.5. Боловсруулах үйлдвэрийн удирдах болон инженер, техникийн ажилтнуудыг нарийн мэргэжлээр өндөр хөгжсөн оронд давтан сургах, туршлага судлуулах, чадавхжуулах, менежментийн болон технологийн сургалтыг зохион байгуулах	2018 - 2021	-		МННХ, Шима Сейки компанийн Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран Японы Шима Сейки сүлжмэлийн бүрэн автомат машинаар үйлдвэрлэлээ явуулдаг компаниудын удирдлагуудыг Шима Сейки компанитай танилцуулах аяллыг зохион байгуулж, Шима Сейки дизайн системийн сургалт, танилцуулгыг хийв. Нийт 15 хүн оролцсон. АХБ-ны санхүүжилтээр Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэнгийн Сорилтын төвийн итгэмжлэгдсэн лабораторид Японы JEOL фирмийн SEM багаж суурилуулж, тоног төхөөрөмжийг нийлүүлэгч талаас ХҮСХХ-ийн шинжээчдийг уг багаж дээр ажиллах чадвар эзэмшүүлэх сургалтыг явуулсан. Арьс ширний үйлдвэрлэлийн боловсруулалтын технологи мэргэжлээр Турк улсын засгийн газрын тэтгэлгээр суралцах сонгон шалгаруулалтад 2 оюутан тэнцэж суралцаж байна.	90%
35	14.4.6. Боловсруулах үйлдвэрийн мэргэжлээр суралцаж байгаа оюутны	2018 - 2020	-		Завхан аймгийн Политехникийн коллеж 2019 онд боловсруулах “С” ангилалын 10 гаруй төрлийн үйлдвэрлэлд мэргэшүүлэх сургалтанд 700 гаруй оюутныг хамруулан зохион байгуулж байна. Арьс шир боловсруулах үйлдвэрлэлийн технологийн чиглэлээр Турк улсын	50%

	сургалтын болон төгсөлтийн дадлагын хугацааг уртасгах, сургалт үйлдвэрлэлийн уялдааг хангах, дадлагын үр өгөөжийг дээшлүүлэх				засгийн газрын тэтгэлэгт сургалтанд 2 оюутан тэнцэн ковид -19 цар тахлын үед цахимаар хичээллэж байна.	
36	14.4.7. Үйлдвэрлэлийн дадлага хийх хугацаанд оюутан сурагчдын хөдөлмөрийг үнэлэх, цалин урамшууллын механизмыг бий болгох	2019 - 2020	-		Мэргэжилтэй ажилтаны эрэлт хэрэгцээг харгалзан үйлдвэр аж ахуйн нэгжүүд өөрсдийн санаачилгаар дараах ажлыг эхлүүлээд байна. Оёмол бүтээгдэхүүн, хувцас үйлдвэрлэгч "Их газрын чулуу" ХХК “Нутгийн ирээдүй” оюутны тэтгэлэгт хөтөлбөрийг 2 чиглэлээр зарласан. Үүнд: 1. Дадлагажигч оюутны сарын тэтгэлэг /50 000₮/ 2. Тухай мэргэжлээр суралцагчийн сургалтын төлбөрийн тэтгэлэг /2 000 000₮/ гэсэн 2 чиглэлээр уралдаан зарлаж шалгаруулан ажилласан.	50%
37	14.4.9. Нарийн мэргэжлийн ажилтнуудыг их дээд сургуулиудад хөнгөвчилсөн, түргэвчилсэн хөтөлбөрөөр сургах	2019 - 2021	-		АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй "ХАА Нэмүү өртгийн сүлжээг дэмжих" техник туслалцааны төсөл нь “Монголын Хаан Ширхэгт” /МХШ/ бүтээгдэхүүний чанарт нийцэх түүхий эдийг бэлтгэх технологийн сургалтын 3 модуль боловсруулж, нийт 14 сургалтаар 4 аймгийн 18 хоршоодын 578 малчид, хоршооны сургагч багш нарыг, үйлдвэрлэлийн түвшинд олон улсын стандартад дүйцэх МХШ гэрчлэх тэмдэгт ээрмэл, нэхмэл, сүлжмэлийн чанар, хяналтын болон гүйцэтгэн боловсруулалтын технологийн сургалтын 5 модулийг аж ахуйн нэгж бүрийн онцлогт суурилан боловсруулж, нийт 16 сургалтыг 15 ААН-ийн ажлын байранд зохион байгуулж, нийт 371 ИТА-ыг хамруулав. “Арьс шир боловсруулах үйлдвэрийн орчин дахь ажлын байрны эмх цэгц ба менежмент”, "LWG Байгаль орчны аудит”, "Арьс шир боловсруулах үйлдвэрийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй", "ISO14001 Байгаль орчны менежментийн системийн дотоод аудитор бэлтгэх", “Гутлын эрүүл ахуй” сэдэвт сургалтуудыг зохион байгуулж олон улсын сертификат олгож, салбарын эрдэмтэн судлаачид, инженерүүд, үйлдвэрлэл эрхлэгчид зэрэг 500 гаруй хүнийг хамруулав.	100%

38	14.4.10. Батлан хамгаалах цэргийн албан хаагчдыг үйлдвэрлэлийн дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажилд оролцуулах талаар зохих шатны төрийн байгууллагуудтай хамтран ажиллах	2018 - 2021	-		Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулах журам"-ыг боловсруулан Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн 2018 оны 01 дүгээр зарлигаар батлуулсан. Мөн "Автозамын бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулах түр журам"-ыг боловсруулан сайдын 2018 оны А/217 дугаар тушаалаар батлуулснаар Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулах эрх зүйн орчин бүрдсэн. Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар БХЯ-ны Зэвсэгт хүчний жанжин штабын дэргэд Ойн цэвэрлэгээ хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг бүтээн байгуулалтад оролцуулах төслийн баг байгуулан ажиллаж байна. Ойн цэвэрлэгээний ажилд шаардлагатай мэргэжилтэй боловсон хүчин, бригад, техник тоног төхөөрөмжийн судалгааг БХЯ-ны Жанжин штабтай хамтран боловсруулан, шаардлагатай хөрөнгө оруулалтыг БНБеларусь, БНХАУ-ын буцалтгүй тусламжаар шийдэрлүүлэхээр төслийг боловсруулан БХЯ-нд танилцуулсан. Ойн цэвэрлэгээний ажлыг гүйцэтгэх бүс нутгийг сонгон, ойн нөөцийг тодорхойлж, дэд бүтцийн ажлын өртөг зардлын тооцоог хийж, техник технологийн сонголтыг мэргэжлийн зөвлөх багаар гүйцэтгүүлэн хүлээн авсан. Дээрх ажлын хүрээнд БХЯ, ХХААХҮЯ, БОАЖЯ хооронд хамтран ажиллах санамж бичиг 2021 онд байгуулахаар төслийг боловсруулж, холбогдох газар албадад танилцуулсан.	90%
39	14.4.11. Асрамж, халамжийн газарт өсөж хүмүүжсэн зорилтот бүлгийн иргэдийг үйлдвэрлэгчидтэй хамтран мини төсөлд хамруулах	2018 - 2020	-		Зорилтот бүлгийн залуучуудыг нийгэмшүүлэх, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр олон нийтэд түшиглэсэн үйл ажиллагааг сайн дурын иргэдийн оролцоотойгоор зохион байгуулна" заалтыг үндэслэн Асрамж, халамжийн төвөөс насанд хүрч нийгмийн харилцаанд орж буй залуучуудыг дэмжих төслийг шинэчлэн, төлөвлөгөө гарган, ЗГХА "Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар"-тай хамтран ажиллахаар 2 удаагийн уулзалтыг зохион байгуулав. Ингэхдээ аймаг, дүүрэг бүрт зорилтот бүлгийн тодорхой тооны залуучуудыг нийгмийн харилцаанд бэлтгэх зөвлөгөө, сургалтад хамруулах, бие даан амьдрахад тулгарах аливаа бэрхшээлийг даван туулах, мэргэжил эзэмших болон хөдөлмөрийн зах зээлд ороход зөвлөх буюу амьдралын зөвлөгчийн зөвлөгөө, дэмжлэгээр хангах зэргээр амьдрах байр, өдөр тутмын амьжиргааны зардлыг тусгасан цогц арга хэмжээг	50%

					хэрэгжүүлэх, үүнд аймаг, дүүргүүдийн ГБХЗХГ болон ЗХТ-ийн оролцоог хангах байдлаар тусгаад байна. 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд Зорилтот бүлгийн иргэдэд мэргэжил эзэмшүүлэн ажлын байраар хангах зорилгоор салбарын үйлдвэрүүдтэй танилцуулан, ажлын байр сургалтад хамрагдах ажлыг зохион байгуулах, сурталчлах ажлыг тусгасан бөгөөд шаардлагатай санхүүжилтийг төсөвт тусгуулсан.	
40	14.4.12. Гадаад оронд ажиллаж байсан, шинэ технологи эзэмшсэн иргэдийг эх орондоо эргэн ирж тухай чиглэлээр үйлдвэрлэл явуулахад санхүү, татварын дэмжлэг үзүүлэх	2018 - 2020	-		Ковидын нөхцөл байдлын улмаас төлөвлөсөн арга хэмжээ хойшилсон.	70%
42	14.4.14. Шинээр байгуулах үйлдвэрүүдэд ажиллах ажилчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцлийг бүрдүүлэх /орон сууц, цалингийн тогтолцоо, урамшуулал/	2019 - 2021	хувийн хэвшил-12, 500.0 сая төг /гадаад орны зээл/		Үйлдвэрүүд ажилчдаа тогтвор суурьшилтай ажиллуулах, ахуй нөхцөлийг нь сайжруулах зорилгоор орон сууц барьж, ажиллагсадныхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар тодорхой ажлуудыг хийж байна. Тухайлбал: "Гоёл кашемир" ХХК нь АНУ-аас 5.0 сая долларын зээл авч үйлдвэрийнхээ дэргэд ажилчдын 80 айлын орон сууц бариулж, гүйцэтгэл нь 70 хувьтай байна.	70%
Зорилт 4-ийн дүн						57.0%
14.5. Зорилтот зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүний тээвэр-ложистикийг боловсронгуй болгож, маркетингийн үйл ажиллагааг хөгжүүлэн дотоод, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх.						
43	14.5.1. Гааль, татвар, мэргэжлийн хяналтын нэг цэгт үзүүлэх тогтолцоог	2019 - 2021	-		ГХЦНЦ-ны үйл ажиллагаатай танилцах арга хэмжээг Малайз, Сингапур улсад зохион байгуулж ГЕГ, МХЕГ-ын удирдах албан тушаалтнууд оролцсон. Арга хэмжээнд ЦНЦ-ны үйлчилгээг нэвтрүүлсэн туршлага, нэвтрүүлж эхлэх үед тулгарч байсан хүндрэл	70%

	бий болгох судалгаа хийх, гадны туршлагыг судлах				бэрхшээл, тэдгээрийг шийдвэрлэсэн арга замын талаар судалсан. Малайзын уг үйлчилгээний хамрах хүрээ, түүний үйлчилгээний бизнесийн болон үйл ажиллагааны онцлог, байгууллагын оролцооны онцлог, ЦНЦ-ны үйлчилгээний системийн техникийн онцлог, Малайз, Сингапурын хилийн боомтын үйл ажиллагаатай танилцан туршлага судалсан. НӨАТ суутган төлөгчөөс ирүүлдэг НӨАТ-ын тайланд импортоор буюу гаалиар бараа оруулж ирсэнийг татвар төлөгч гараар шивж оруулдаг байсныг ГЕГ-тай хамтран байгуулсан гэрээний үндсэн дээр цахимаар шууд гаалийн серверээс татаж тайлагнах хөгжүүлэлтийг цахим татварын системд /e-tax.mta.mn/ хийж нэвтрүүлж байна.	
44	14.5.2. Экспортын нэг цонхны бодлого хэрэгжүүлж, гааль, татвар, мэргэжлийн хяналт зэрэг төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр, эсхүл нэг цэгт үзүүлэх "цаасгүй бүрдүүлэлт"-г нэвтрүүлэх	2019 - 2020	-		Импортоор оруулж бараа, бүтээгдэхүүнийг бүртгэхдээ БТКУС-ын код дээр суурилсан шинэ барааны кодыг Цахим төлбөрийн системд нэвтрүүлж байна. Төлбөрийн баримт хэвлээгүй бол хил гаалиар гарах боломжгүй байхаар хяналтыг хийхээр хөгжүүлэлт хийх холбогдох журам, аргачлалд нэмэлт оруулж тодорхойлсноор нэвтрүүлэх боломжтой. Экспортын бүтээгдэхүүний тоо хэмжээ, чанар, агууламжийг үйлдвэрлэгчээс урьдчилан тодорхойлуулан хилээр гарах үед бүхий л шаардлагатай мэдээллийг цуглуулах, импортын бүтээгдэхүүнийг эцсийн хэрэглэгч хүртэл татварын удирдлагын нэгдсэн систем болон гаалийн мэдээллийн системд тулгуурлан бүртгэлжүүлэх програм хангамжийг хөгжүүлж, олон улсын стандартад нийцсэн зураасан код ашиглан татварын цахим төлбөрийн баримтын систем нэвтрүүлэх ажлыг гаалийн байгууллага хийж гүйцэтгэж байна. БНСУ-ын Үндэсний гаалийн мэдээллийн сүлжээний үйл ажиллагааны холбоо (CUPIA)-ноос хэрэгжүүлж байгаа “Гаалийн байгууллагын шинэчлэл” төслийн багийг ханд гаалийн бүрдүүлэлтийн CAIS програмд гаалийн бүрдүүлэлт хэрхэн хийгдэж байгаа талаар өмнө нь 3 удаа уулзаж ярилцсан бөгөөд 2019.09.17-нд дээрх төслийн баг ирээдүйн загварыг танилцуулсанд саналаа өгч хэлэлцсэн. Системийг боловсронгуй болгож, нийтдээ 22 ажлыг хийх шаардлагатай гэж үзсэн бөгөөд үүнд цахим нэг цонхны хөтөлбөр хэрэгжүүлэх ажил багтсан болно. Татварын алба нь 2019 оны 03 сарын 01-нээс Татварын удирдлагын нэгдсэн системийг хэрэгжүүлж эхэлснээр татвар төлөгчөөр бүртгүүлэх, татварын төлөлтийг татварын	70%

					албанд, банкинд өөрийн биеэр очихгүйгээр цахимаар хийх боломжийг бүрдүүлсэн.	
45	14.5.5. Монгол Улсаас ОХУ-д нийлүүлэх бүтээгдэхүүний тарифын болон тарифын бус хориг саадыг бууруулахад чиглэгдсэн үйл ажиллагааг шат дараалалтайгаар зохион байгуулах	2019 - 2020	-		Монгол Улсаас ОХУ-д нийлүүлэх бүтээгдэхүүний тарифын болон тарифын бус хориг саадыг бууруулахад чиглэгдсэн саналыг яриа хэлэлцээний бүхий л түвшинд илэрхийлж байна. ОХУ-ын зүгээс Евроазийн эдийн засгийн холбооны хүрээнд Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах замаар асуудлыг шийдвэрлэх нь зохистой гэсэн санааг удаа дараа илэрхийлсэн бөгөөд Евразийн эдийн засгийн холбоотой чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах хамтарсан судалгааны ажлыг эхлүүлэхээр ажлын хэсэг байгуулагдсан. монгол талын ажлын хэсэгт орсон хүмүүс холбогдох сургалтад хамрагдаад байна.	50%
46	14.5.6. Монгол брэнд бүтээгдэхүүнийг дэлхий нийтэд сурталчлах, таниулах "Хаан ширхэгт" брэндийг үйлдвэрлэн, гэрчилгээ олгох, сурталчлах	2019 - 2021	-		Азийн хөгжлийн банкны Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн шугамаар Монголын ноос, ноолуурын холбооны дэргэд баталгаажуулалтын албыг байгуулсан. Тус "Баталгаажуулалтын алба" нь олон улсын MNS ISO/IEC17065 стандартын шаардлагыг бүрэн хангасан тул үндэсний болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн төдийгүй Монгол Улсын ноос ноолуурын салбарын "Тохирлын үнэлгээ-Бүтээгдэхүүн, үйл явц, үйлчилгээний баталгаажуулалт"-ыг явуулах эрх бүхий анхны байгууллага болсон бөгөөд Монгол Улс ноолууран бүтээгдэхүүнээ "Монголын Хаан ширхэгт" чанарын тэмдэгээр баталгаажуулан эскпортонд гаргаж эхэлсэн. "Монголын хаан ширхэгт" сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүний чанарын стандартыг шинээр боловсруулан СХЗГ-ын ноос, ноолуурын стандартчилалын техникийн хороогоор хэлэлцүүлэн батлуулав. -АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй "ХАА Нэмүү өртгийн сүлжээг дэмжих" техник туслалцааны төсөл нь "Монголын Хаан Ширхэгт" /МХШ/ бүтээгдэхүүний чанарт нийцэх түүхий эдийг бэлтгэх технологийн сургалтын 3 модуль боловсруулж, нийт 14 сургалтаар 4 аймгийн 18 хоршоодын 578 малчид, хоршооны сургагч багш нарыг, үйлдвэрлэлийн түвшинд олон улсын стандартад дүйцэх МХШ гэрчлэх тэмдэгт ээрмэл, нэхмэл, сүлжмэлийн чанар, хяналтын болон гүйцэтгэн боловсруулалтын технологийн сургалтын 5 модулийг аж ахуйн нэгж бүрийн онцлогт суурилан боловсруулж, нийт 16 сургалтыг 15 ААН-	100%

					ийн ажлын байранд зохион байгуулж, нийт 371 инженер техникийн ажилтныг хамруулав.	
47	14.5.7. "Нэг сум-нэг бренд" аян өрнүүлэх	2019 - 2021	-		"Нэг сум-нэг бүтээгдэхүүн" аяныг зохион байгуулах удирдамжийг Жижиг, дунд үйлдвэрийн газрын даргын 2020 оны А-54 тушаалаар батлуулан орон нутагт хүргүүлэн аймгийн ХХААГ-аас бренд бүтээгдэхүүн шалгаруулах, бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийх, бренд бүтээгдэхүүний дэлгүүр нээх зэрэг арга хэмжээ зохион байгуулсан. Увс аймагт Брендийн зөвлөлийг байгуулан ажилдаа ороод байна. Хавсралт : 1 файл	70%
48	14.5.8. Үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүнийг худалдааны түнш орнуудад сурталчлах, ЭКСПО-д оролцоход дэмжлэг үзүүлэх	2019 - 2020	7.3 сая төг		Үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээ, брэнд бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчлах, олон улсын стандартад нийцсэн бараа бүтээгдэхүүнийг экспортлох, шинэ зах зээлд гаргах, түншлэлийг бий болгох зорилгоор "Улаанбаатар түншлэл-2020" Олон улсын үзэсгэлэн худалдааг 2020.09.24-27-ны өдрүүдэд МҮХАҮТ-ай хамтран зохион байгуулсан. Үзэсгэлэн худалдаанд нийт 110 ААН оролцсон. - "Монгол экспорт экспо-2020" дотоодын үзэсгэлэн худалдааг 2020.11.15-20-ны өдрүүдэд Мишээл экспо төвд зохион байгуулав. Үзэсгэлэн худалдаанд ноос, ноолуур, арьс ширний үйлдвэрлэлийн салбарын 108 үйлдвэрлэгчид оролцож, 300 гаруй сая төгрөгийн борлуулалт хийж, нийт 6000 гаруй хүн хамрагдан худалдан авалт хийсэн. "Экспорт монгол 2020" Олон улсын цахим форум, сургалт, виртуал үзэсгэлэнг ГХЯ, ҮХГазар, Экспорт олон улсын худалдааны төв ТББ-тай хамтран 2020.12 сард зохион байгуулсан. Тус арга хэмжээнд ТНБД Т.Жамбалцэрэн, ХөнҮБХЗГ-ын дарга М.Дондогдорж илтгэл тавин оролцож, панелистаар БТГ-ын дарга Ц.Болорчулуун, ЖДҮГ-ын дарга Я.Эрдэнэсайхан нар оролцлоо. Арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан цахим үзэсгэлэн худалдаанд хөнгөн, хүнсний салбарын нийт 43 ААН 200 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүнээр оролцсон бөгөөд 10 гаруй орноос давхардсан тоогоор 24000 гаруй удаагийн хандалт хийж, сайтад байршуулсан ААН-ийн материалуудаас 200 гаруй материалыг татаж авсан байна. Нийт арга хэмжээний хүрээнд https://www.expromongolia.org/ хаягаар АНУ, Япон, Австри, ХБНГУ, Франц, ОХУ, БНХАУ, Их Британи, Сингапур, Вьетнам, Болгар, Чех, Польш, БНСУ зэрэг 20 орчим улсын 360 гаруй, дотоодын 1600 гаруй	100%

					оролцогч бүртгүүлэн оролцсон бөгөөд бусад олон нийтийн сүлжээ, цахим хуудсаар 6400 гаруй удаагийн хандалт хийсэн. ДБ-ны төв байранд 5 дахь удаа Монголын соёлын өдрүүд арга хэмжээний хүрээнд “Монголд үйлдвэрлэв” үзэсгэлэнг 2020.02.06-02.13 өдрүүдэд зохион байгуулав. Уг арга хэмжээг ХХААХҮЯ, Экспорт олон улсын худалдааны төв, ДБ, Олон Улсын Санхүүжилтийн корпорацн хамтран зохион байгуулсан.	
49	14.5.9. "Монгол-Хятадын Экспо"-г тогтмол зохион байгуулах	2019 - 2021	-		Уг арга хэмжээг 2 жил тутамд хийдэг. Өмнөх арга хэмжээг 2019 онд БНХАУ-ын ӨМӨЗО-нд 2 улс хамтран амжилттай зохион байгуулсан. Ирэх 2021 онд Монгол Улсад зохион байгуулагдана.	100%
50	14.5.10. Үндэсний үйлдвэрийн бараа бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх худалдааны нэгдсэн портал сайт, аппликейшн бий болгох	2019 - 2020	-		“Улаанбаатар инновацийн төв”-д бойжиж буй гарааны компани болох “Амар и коммерси” ХХК-иас үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүнийг борлуулах худалдааны онлайн сайтыг 2018 онд хийж гүйцэтгэсэн. Тус онлайн худалдааны Авлаа.мн сайтад дотоод, гадаадын 1200 гаруй бренд бүтээгдэхүүнийг байршуулан, 2018.03.15-нд нээлтээ хийж үйл ажиллагаагаа эхлүүлэн ажиллаж байна. Алибаба компанид хамтран ажиллах санал хүргүүлсэн. 2018.01.17-ны өдөр Аж үйлдвэрийн цахим мэдээллийн системд үйлдвэрлэгчдийн мэдээллийг нэгтгэх ажлыг эхлүүлсэн бөгөөд 2019 оны байдлаар 3700 үйлдвэр мэдээллээ системд оруулсан. ҮХГ, Оюун толгой компани Аж үйлдвэрийн цахим мэдээллийн санг ашиглах тухай харилцан ойлголцлын санамж бичиг зурсан. Тус цахим системийг "Оюу толгой" ХХК-ийн худалдан авалтын "Монголд үйлдвэрлэв" бодлогын хүрээнд Монгол улсад үйлдвэрлэл эрхэлж буй үйлдвэрлэгчид болон зах зээлийн талаарх судалгаа, шинжилгээ хийх болон худалдан авалтын зарыг илүү оновчтой түгээх үйл ажиллагаанд ашиглах боломжтой болно. Мөн үйлдвэрлэл эрхлэгчдийг гадаад худалдаа, хөрөнгө оруулагч нарт сурталчлах, мэдээ мэдээлэл түгээх зорилготойгоор "Германы Олон Улсын Нийгэмлэг GIZ"-ийн Эрдэс баялаг түүхий эдийн иж бүрэн санаачилга төсөлтэй хамтран Аж үйлдвэрийн цахим мэдээллийн санг хөгжүүлж байна.	70%
51	14.5.11. УБ хотын баруун, зүүн талд мал эмнэлэг, эрүүл	2018 - 2020	-		Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд тус төсөл Улаанбаатар хотын баруун талд буюу Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хорооны 15 га, хотын зүүн талд буюу Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны 14.5	70%

	ахуй, ариун цэврийн шаардлага хангасан үйлдвэрийн аргаар боловсруулсан мах, ногооны төрөлжсөн бөөний худалдааны төв байгуулахад дэмжлэг үзүүлэх				га талбайд хэрэгжиж байна. Хоногт 7500 толгой бог, 1500 толгой бод төхөөрөх хүчин чадалтай үйлдвэр, 11000 тн агуулах, малын зах, худалдааны төв бүхий цогцолбор байгуулах тус төслийн дэд бүтэц баригдсан, бүтээн байгуулалтын ажил 60 хувьтай үргэлжилж байна. Хөгжлийн банкнаас тус төсөлд 2018 оны 2 дугаар сард 6.9 тэрбум, 2019 оны 6 дугаар сард 4.6 тэрбум төгрөгийн зээлийг жилийн 13.01 хувийн хүүтэй, 5 жилийн хугацаатайгаар олгосон байна. Төслийг эрчимжүүлэх, санхүүгийн богино хугацааны хүндрэлийг арилгах зорилгоор НЗДТГ-аас болон тус компаниас ирүүлсэн албан хүсэлтүүдийг харгалзан бүтээн байгуулалтад шаардлагатай тоног төхөөрөмж, материалын гаалийн болон НӨАТ төлөх хугацааг хойшлуулах талаар санал боловсруулж яамдаас санал авч нэгтгэн ЗГХЭГ-т 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 01/4144 тоотгоор хүргүүлсэн. Тус тогтоолын төслийг Засгийн газрын 2019 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж дэмжсэн. Засгийн газрын тогтоолын хүрээнд дээрх төслийн бүтээн байгуулалтад шаардлагатай тоног төхөөрөмж, материалын гаалийн болон НӨАТ төлөх хугацааг хойшлуулах 4 талт гэрээг /Сангийн яам, ХХААХҮЯ, Нийслэлийн Засаг дарга, тухайн аж ахуйн нэгж/ хамтран байгуулсан.	
52	14.5.12. Сав, баглаа боодлын захиалгын болон худалдааны цэгийг байгуулахад дэмжлэг үзүүлэх	2018 - 2020	ЖДҮХС-1.060,2 сая төг		Орон нутагт 1 үйлдвэр шуудай, хэвлэлийн 7 үйлдвэр цаасан уут, хаяг шошгыг, оёдлын нэг хоршоо даавуун тор, уутыг үйлдвэрлэж, иргэд, албан байгууллагад нийлүүлж байна. ХХААХҮ-ийн Сайдын 2020 оны А-131 дугаар тушаалаар батлуулж, 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар сав, баглаа боодлын үйлдвэрлэлийн 7 ААН-д 1,060,200,000 төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон байна.	70%
					Зорилт 5-ын дүн	77.0%
					ХШҮ-ний дундаж дүн	78.8%